



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 37

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 107,651,657 /нэг зуун долоон сая зургаан зуун тавин нэгэн мянга зургаан зуун тавин долоон/ төгрөгийн хавсралт дахь хөрөнгийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны харъяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-т шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Г.Мягмарсүрэнд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20...~~...~~ны 12 сарын 13-дрийн 33 дугаар тогтоолын хавсралт

Шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Сумын нэр	Ашиглалтанд орсон огноо	Хөрөнгийн нэр	Үнийн дүн
1	Дэрэн	2015	0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл	64,364,690.0
2	Дэрэн	2013	10/0.4 кВ-ын дэд станц, 10 кВ-ын 0.8 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам	25,736,967.0
3	Сайнцагаан	2016	Мод үржүүлгийн талбайн гүний худгийн 6/0.4 кв 50 ква чадалтай АТП-ын барилга	17,550,000.0
Нийт дүн				107,651,657.0